



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 336

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө бүртгэх
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1, “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээ”-ний тухай Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1.а дахь заалт, 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн “Томоохон баг, суурин газруудыг эрчим хүчээр хангах, сумдын 0,4 кВ-н шугамын өргөтгөл, шинэчлэлт /Улсын хэмжээнд/” төсөл арга хэмжээний хүрээнд Багц-14 Хөвсгөл аймгийн Галт сумын Зүрх баг, Их-уул сумын цахилгаан дамжуулах агаарын шугамын шинэчлэл барилга угсралтын ажлын хүрээнд бий болсон, 6 нэрийн нийт 970,000.000.00 (есөн зуун далан сая) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг “Эрдэнэт булганы цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Насантогтох, “Эрдэнэт булганы цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Г.Баярцогт нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг компанийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



006701

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2020 оны 17 дугаар сарын 26 ны өдрийн
336 дугаар тогтоолын хавсралт

**"ЭРДЭНЭТ БУЛГАНЫ ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Байршил /Хөвсгөл аймаг/	Ашиглалтад орсон он	Хүчин чадал		Балансын үнэ /төгрөг/
				хэмжих нэгж	Тоо хэмжээ	
1	Нарны цахилгаан станц 80 кВт	Галт сум	2019.07.08	ш	1	202,892,587.00
2	Цахилгаан дамжуулах агаарын шугам-0.4 кВ-ын	Галт сум	2019.07.08	км	1.2	42,517,253.00
3	Цахилгаан дамжуулах агаарын шугам-0.4 кВ-ын	Их-Уул сум	2019.07.08	км	5.717	139,258,115.00
4	Цахилгаан дамжуулах агаарын шугам-10 кВ-ын	Их-Уул сум	2019.07.08	км	3.11	117,453,163.00
5	Цахилгаан дамжуулах агаарын шугам-35 кВ-ын	Их-Уул сум	2019.07.08	км	0.054	35,129,393.00
6	Дэд станц-35/10 кВ-ын 1*1000 кВа	Их-Уул сум	2019.07.08	ш	1	432,749,489.00
Нийт дүн						970,000,000.00 (есөн зуун далан сая)